

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫГ ОГЦРУУЛАХ ЭСЭХ АСУУДЛААР ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ

2014 оны 11 дүгээр  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн А.Бакей

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Д.Хаянхярваа нарын нэр бүхий 28 гишүүн Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн 2014 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлжээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо уг асуудлыг 2014 оны 10 дугаар сарын 22, 2014 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, Улсын Их Хурал дахь МАХН-МҮАН-ын “Шудрага ёс” эвслийн бүлэг ажлын 5 хоног, Ардчилсан намын бүлэг ажлын 3 хоногийн хугацаатай завсарлага тус тус авсан болно.

Төрийн байгуулалтын байнгын хороо уг асуудлыг 2014 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах тухай саналыг Улсын Их Хурлын гишүүн Д.Хаянхярваа танилцуулсан бөгөөд уг саналд Монгол Улсын Ерөнхий сайд Үндсэн хууль болон холбогдох бусад хуулийг удаа дараа зөрчсөн, эдийн засаг хямралд орсон, өрийн хэмжээг хуульд заасан хэмжээнээс хэтрүүлсэн, бондыг үр ашиггүй зарцуулсан, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг биелүүлж чадаагүй, “Эзэн-100” хөтөлбөрийн биелэлт хангалтгүй, үр ашиггүй бүтэц, орон тоо нь улам нэмэгдсэн, сайд нартаа хариуцлага тооцохгүй байгаа зэрэг огцруулах үндэслэлүүдийг тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, Р.Гончигдорж, Р.Бурмаа нар өөрсдийн байр суурийг илэрхийлэн үг хэлэв. Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, Р.Гончигдорж нар шүүхээр гэм буруутай нь тогтоогдоогүй байхад буруутай мэт мэдэгдэл хийх нь хариуцлагагүй үйлдэл, хүний эрх, Үндсэн хууль зөрчсөн асуудлыг Улсын Их Хурал хүлээн авч хэлэлцэх нь буруу, бусдын гэм буруутай үйлдлийг халдаан хэрэглэж болохгүй, Улсын Их Хурлын гишүүд санхүү, эдийн засагтай холбоотой мэдээ, мэдээллийг эрх бүхий байгууллагаас нотлогдсон баримтанд тулгуурлах хэрэгтэй, бид нийт ард түмний элч төлөөлөгчийн хувьд ард түмэндээ үнэн зөв мэдээллийг өгөх үүрэгтэй бөгөөд хүний нэр төр алдар хүндэд халдсан бол Улсын Их Хурлын гишүүн ёс зүйн болон албан тушаалын хариуцлага хүлээх ёстой. Энэ асуудал Улсын Их Хурлын гишүүн хэлсэн үгнийхээ төлөө хариуцлага хүлээхгүй гэсэнд хамаарахгүй гэж санал хэлсэн. Улсын Их Хурлын гишүүн Р.Бурмаа Ерөнхий сайд ёс зүйн болон улс төрийн хариуцлага хүлээж огцрох ёстой гэж үзэж байгаа тул огцруулах санал оруулсан гишүүдийн огцруулах үндэслэлийг дэмжсэндээ бус өөрийн итгэл үнэмшилээр Ерөнхий сайдыг огцруулах

саналыг дэмжиж байгаага илэрхийлэв.

Байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах эсэх асуудлаар санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх огцруулах саналыг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах эсэх тухай асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



А.БАКЕЙ